


Улаанбаатар хотын хүйтний улирал буюу 2011-2014 оны 1-4, 10-12 дугаар сарын агаарын чанарын төлөв байдал

Цаг уур, орчны шинжилгээний газар нь Улаанбаатар хотын агаарын чанарыг гэр хороолол, автозам, орон сууцны хороолол, үйлдвэрийн дүүрэг орчимд автомат болон автомат бус багажаар 2-5 төрлийн үндсэн бохирдуулах бодисыг тодорхойлон хянаж байна.


Өнгөрсөн 2013-2014 оны хүйтний улирлын (2013 оны 10-12 дугаар сар, 2014 оны 1-4 дүгээр сар) бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2012-2013 оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хий **8 мкг-аар** буюу **20%-иар**, нарийн ширхэглэгт тоосонцор **27 мкг-аар** буюу **21%-иар**, азотын давхар исэл **18 мкг-аар** буюу **26%-иар** тус тус бага байсан бол том ширхэглэгт тоосонцор өмнөх жилийн мөн үеийн түвшинд байсан байна.

Харин 2014 хүйтний улирлын 10-р сард Улаанбаатар хотын агаарын чанарын төлвийг тодорхойлох хяналтын цэгүүдэд хийсэн агаар бохирдуулах бодисын сарын дундаж агууламжийг 2013 оны мөн үетэй харьцуулахад том ширхэглэгт тоосонцор **3 мкг-аар** буюу **2%-иар**, азотын давхар исэл **9 мкг-аар** буюу **17%-иар** тус тус бага, нарийн ширхэглэгт тоосонцор **4 мкг-аар** буюу **7%-иар** их бол хүхэрлэг хий өмнөх жилийн түвшинд байна.


Улаанбаатар хотын сүүлийн 3 жилийн хүйтний улирлын (10-12 дугаар сар, 1-4 дүгээр сар) агаарын чанарын төлвийг гол бохирдуулах бодис тус бүрээр дараах зургуудад харууллаа.




Азотын давхар ислийн сарын дундаж агууламж
/2011-2014 оны 10-12, 1-4 дүгээр сар/



Том ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж
/2011-2014 оны 10-12, 1-4 дүгээр сар/



Нарийн ширхэглэгт тоосонцрын сарын дундаж агууламж
/2011-2014 оны 10-12, 1-4 дүгээр сар/



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР